






ХҮНИЙ ЭРХ ХӨГЖИЛ ТӨВИЙН 2024 ОНД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

I. СУРГАЛТ/ СУДАЛГАА

1. “Орон нутгийн иргэд хүний эрхийг хамгаалах, хангах үндэсний тогтолцоо, механизмтай хамтарч ажиллах нь” сургалтыг 2024 оны 2 сарын 29, 3 сарын 1-ний өдөр Дорноговь аймгийн Сайншанд суманд амжилттай зохион байгуулж, сургалтанд Дорноговь аймгийн Даланжаргалан, Улаанбадрах, Хатанбулаг сум тус бүрээс 10 иргэн оролцуулж, нийт 30 оролцогчдыг хамрууллаа. Мөн тус сургалтад сумын иргэд, малчид, ЗДТГ-ын ажилтнууд, багийн дарга нар, сумын ИТХ-ын төлөөлөгчдийн төлөөллөөс оролцсон болно. Сургалт нь дараах хоёр зорилготой. Үүнд:

а/ Хүний эрхийн зөрчлийг баримтжуулах, баримтыг нотлогоо болгон хэрэглэхэд тавигдах хуулийн шаардлага, Хүний эрхийн Үндэсний Комисс, орон нутаг дахь ХЭҮК-ын төлөөлөгчид өргөдөл гаргах журам, маягт, хүний эрхийн зөрчлийг арилгахад хамтран ажиллах боломж зэрэг асуудлаар мэдээлэл авна. Мэдээллийг ХЭҮК-ын ажилтан, ХЭҮК-ын орон нутгийн төлөөлөгч өгч, асуултанд хариулах, харилцан ярилцах хэлбэрээр зохион байгуулна.

б/ Орон нутагт хүний эрхийг хангах зорилгоор Хүний эрхийг Хангах Үндэсний Хорооноос хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, үүнд орон нутгийн иргэд, төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгжүүд хэрхэн хамтран ажиллах тухай танилцуулна.



2. “Орон нутгийн түвшинд хэрхэн төсөв, төсвийн үйл явцад оролцох, хянах вэ?” сургалт

Сургалтыг Дорноговь аймгийн Даланжаргалан 3 сумд 2024 оны 3 сарын 15-16-нд, Хатанбулаг сумд 3 сарын 18-19-нд, Улаанбадрах сумд 3-р сарын 21-22-нд тус тус зохион байгууллаа. Сургалтанд 3 сумын нийт 108 хүн хамрагдан, сум бүрээс иргэд, малчид, бүлгийн гишүүд болон ЗДТГ-ын ажилтнууд, багийн дарга нар, сумын ИТХ-ын төлөөлөгчдийн төлөөлөгчид оролцлоо. Сургалт нь дараах хоёр зорилготой байлаа. Үүнд:

1. Төсөв гэж юу болох, төсвийн цагалбар, төсөвт иргэд оролцох шалтгаан, ОНХС, төсвийн хөрөнгө оруулалт үр дүн, үр ашигт хяналт тавих талаар шаардлагатай мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дөрвөн модуль хичээл

2. 3 сум дээр бүлэг зохион байгуулалтанд орох, бүлэг байгуулах, холбоо болон хамт олныг хөгжүүлэх сан байгуулах ач холбогдолын тухай ойлголт, мэдээлэл өгч хамтран ажиллах



3. ХЭХТ нь орон нутгийн иргэдийн чадавхийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор “Бизнес ба хүний эрх” хөгжлийн асуудлаар иргэд-манлайлсан судалгаа хийх аргачлалыг боловсруулан судалгааны багийг Өвөрхангай аймагт бүрдүүлж, хэрхэн иргэд манлайлсан судалгаа хийх талаар сургалтыг 2024 оны 11-р сарын 14-15-ны өдрүүдэд МХБХ-ны гишүүд болон орон нутгийн ТББ-ын ажилтнуудад зохион байгууллаа. Судалгааны багийн гишүүд 100 гаруй иргэдээс судалгаа асуумж бөглүүлж, нотолгоо баримт дээр тулгуурлан кэйс цуглуулж нөлөөллийн ажлуудыг амжилттай зохион байгуулав.



бүтээлч хамтын оролцоо, боломжит шийдлийг хамтдаа тодорхойлоход туслах уулзалт, цуглаан орон нутагт дутагдаж байгаа тул ХЭХТ нь энэ цоорхойг нөхөн талууд асуудлаа ярьж хэлэлцэх боломжийг бүрдүүлэх олон талын уулзалтыг “Асуудлаа ярилцан хамтарч ажиллацгаая!” уриан дор зохион 2024 оны 05-р сарын 21-ний өдөр Дорноговь аймгийн Сайншанд хотод зохион байгуулав.



СУМАНДАА ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ЦОГЦЛООЁ, ИРГЭНИЙ ОРОН ЗАЙ, АРДЧИЛЛЫГ БЭХЖҮҮЛЬЕ! ОЛОН ТАЛЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ: АСУУДАЛ БА ШИЙДЭЛ

Манай улсад тогтвортой хөгжлийг орон нутагт хэрэгжүүлэх, ТХЗ, зорилтуудын хэрэгжилт орон нутагт ямар байгааг үнэлэх, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг ТХЗ, зорилтуудтай уялдуулан иргэдийн бодит оролцоотой үнэлдэг, ярилцдаг олон талын хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулдаг болох хэрэгцээ, шаардлага байна. Үүнийг хангах зорилгоор энэхүү олон талын хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлгийг Сумын ИТХ, Засаг даргын Тамгын газартай хамтарч боловсрол, эрүүл мэнд, байгаль орчин, газрын харилцаа, мал эмнэлэг, иргэдийн оролцоо, эрх зүй г.м асуудал хариуцсан сумын албан хаагчид, багийн дарга, иргэд, малчдын төлөөлөл бүхий иргэд 2024 оны 5 дугаар сарын 24-нд *Дорноговь аймгийн Хатанбулаг сум*, 2024 оны 05 сарын 27-ний өдөр *Улаанбадрах сум*, 2024 оны 05 сарын 29-ний өдөр *Даланжаргалан сум* дээр тус тус амжилттай зохион байгуулж нийт 100 гаруй хүн оролцлоо.

Хэлэлцүүлгийн үр дүнд иргэд орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн тухай мэдээлэлтэй болж, хөгжлийн ирээдүйн төлөвийг тодорхойлоход санал бодлоо солилцлоо.

III. НӨЛӨӨЛЛИЙН АЖЛУУД **НИЙТИЙН СОНСГОЛУУД /3 АЙМГИЙН 3 СУМАНД**

Эдийн засаг нийгэм соёлын эрхийн Сүлжээ (ЭЗНСЭС) олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр "Уур амьсгалын өөрчлөлтийн хохирол, хор уршгийн тухай ИРГЭД МАНЛАЙЛСАН СУДАЛГАА" төслийг Хүний Эрх Хөгжил Төвийн харъяа Дорнод аймгийн Баяндун, Сүхбаатар аймгийн Дарьганга, Хэнтий аймгийн Мөрөн сумдын Мөнгөн



Хэнтий аймаг, Мөрөн сум
2024.07.03



Дорнод аймаг, Баяндун сум
2024.07.05



Сүхбаатар аймаг, Дарьганга сум
2024.07.07

Хуримтлалын Бүлгүүдийн Холбоодын хамт хамтарч хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд судалгаааны баг болон бүлгийн гишүүд сум бүрт нөлөөллийн ажлууд хийн, сум бүрт нийтийн сонголыг зохион байгуулан, холбогдох байгууллагуудын урьж өөрсдийн дуу хоолойгоо өргөж, зөвлөмж СЗДарга нартаа гардуулан өглөө.

18 ДАХЬ МХБХ-НЫ ТУРШЛАГА СОЛИЛЦОХ УУЛЗАЛТ

18 дахь туршлага солилцох уулзалт нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Их нартын ТХГ, 2024.07.16-21-ны хооронд явагдав. Туршлага солилцох уулзалтыг Даланжаргалан, Улаанбадрах, Хатанбулаг сумын бүлгийн гишүүд амжилттай зохион байгууллаа. Уулзалтын зорилго нь МХБ-үүдийн өнгөрсөн онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хэлэлцэж, харилцан туршлага судлах, хамтран ажиллах, Дорноговь аймгийн байгалийн үзэсгэлэнт газруудтай танилцах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, өөрсдийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, цаашдын стратегийг боловсруулахад оршив. Тус арга хэмжээнд Дорноговь, Дорнод, Хэнтий, Сүхбаатар, УБ хотын МХБүлэг, холбоодын гишүүд болон ХЭХТ-ийн хамт олон оролцлоо.

IV. ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨГӨӨН, ХЭЛЭЛЦҮҮЛГҮҮД

МОНГОЛЫН АРДЧИЛЛЫГ БЭХЖҮҮЛЭХЭД ИНБ-ЫН ОРОЛЦОО: ЗАМЫН ЗУРАГЛАЛ

Хүний эрх хөгжил төв нь иргэний нийгмийн 10 гаруй байгууллагатай баг бүрдүүлж "Ардчиллын үнэлгээ, сорилтууд" цахим судалгааг Монголын ИНБ-дын дунд зохион байгуулсан. Судалгааны дүнг танилцуулах хэлэлцүүлгийг 2023 оны 8 сарын 1-нд зохион байгуулсан билээ. Энэ судалгааны дүгнэлт дээр үндэслэн Монголын иргэний нийгмийн байгууллагууд ардчиллын институтэд чиглэсэн үйл ажиллагааныхаа үр дүнг нэмэгдүүлэх, өөрсдийн ур чадвар, зохион байгуулалтаа сайжруулах замаар ардчиллыг бэхжүүлэхэд оруулах хувь нэмрийн зураглалын төслийг боловсруулж, 2024 оны 8-р сарын 14-нд судалгааны дүнгийн хэлэлцүүлэг зохин байгуулж үндэсний болон орон нутгийн түвшинд үйл ажиллагаа явуулдаг 30 орчим ИНБ-уудын төлөөллийг урьж оролцуулан ардчиллын замын зураглалыг гарган хэлэлцүүлсэн юм.



ЮПР-ЫН ДУНД ХУГАЦААНЫ ҮНЭЛГЭЭ: ОЛОН ТАЛЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Хэлэлцүүлгийг 2024 оны 9 сарын 30-нд зохион байгуулав. Хэлэлцүүлэгт ХЭФ-ын гишүүн байгууллагуудаас гадна бусад иргэний нийгмийн байгууллагууд, УИХ-ын гишүүн, төрийн холбогдох яам, агентлаг, НҮБ-ын суурин төлөөлөгч, олон улсын байгууллагууд, элчин сайдын яамд зэргээс нийт 90 орчим хүмүүс оролцсон. Хэлэлцүүлэгт ХЭФ-ын 4 баг үнэлгээгээ танилцуулж асуултанд хариулсан. Мөн хэвлэл мэдээллийн ажилтнуудад зориулж Хэвлэлийн бага хурал зохион байгуулан олон нийтэд мэдээлэл хүргэсэн.



ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧДЫН ҮНДЭСНИЙ 6 ДУГААР ЗӨВЛӨГӨӨН

Зөвлөгөөн нь “Хүний эрх Хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтыг сайжруулах нь: Асуудал ба шийдэл сэдвийн дор амжилттай зохион байгуулагдаж, нийт 80 гаруй хүн оролцлоо. Тус арга хэмжээ нь 2024 оны 10 дугаар сарын 1-2 -ны өдөр Рамада зочид буудалд явагдсан ба энэхүү арга хэмжээнд ХЭХ-чид болон холбогдох оролцогч талууд хамтдаа ХЭХ-дад үзүүлэх дэмжлэг, тэдний хэрэгцээ, шаардлагын талаарх өөрсдийн үзэл бодлоо хуваалцан байр сууриа нэгтгэж, холбогдох талууд болон олон нийтэд хүргэн хоёр өдрийн турш хэлэлцүүлэг хийлээ. Тус Үндэсний зөвлөлдөх уулзалт нь дараах зорилтуудыг хэрэгжүүлсэн.Үүнд:

- 1) Монгол Улсад ХЭХ-чийн үндэсний сүлжээг бэхжүүлж, хамгаалагчид болон тэднийг дэмжихэд оролцдог бусад оролцогч талын хоорондын харилцааг бэхжүүлэх;
 - 2) ХЭХ-ийг хамгаалах хуулийн хэрэгжилт, хуулийн үр нөлөө, түүнийг сайжруулах боломжийг үнэлэх;
 - 3) Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хүний эрх хамгаалагчийн хорооны үйл ажиллагаа, холбогдох суваг зэрэг асуудлаар ХЭХ-дын мэдлэг, ойлголтыг сайжруулах;
 - 4) ХЭХ-дын үйл ажиллагааг дэмжих, аюулгүй байдлыг хангах арга зам, боломжийг нэмэгдүүлэх талаар хэлэлцэх.
- Тус арга хэмжээ нээж УИХ-ын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д. Цогтбаатар, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Хүний эрх хамгаалагчийн хорооны дарга С. Дондов, Глоб Интернэшнл Төв-ийн Удирдах зөвлөлийн дарга Х. Наранжаргал, ХЭХ, Дорноговь аймгийн Улаанбадрах сумын иргэн Д. Гантөр нар нээж үг хэллээ.



СУРГАЛТ/СУДАЛГАА:

6. Орон нутгийн иргэд хүний эрхийг хамгаалах, хангах үндэсний тогтолцоо, механизмтай хамтарч ажиллах нь /2024.02.29-3.03.01 Дорноговь аймгийн Сайншанд
7. Орон нутгийн СУМАтүвшинд иргэд хэрхэн төсөв,төсвийн үйл явцад оролцох вэ? Дорноговь аймгийн Даланжаргаланд 2024.03.15-16, Хатанбулаг сум 03.18-19, Улаанбадрах сум 03.21-22
8. Сургалт - ТХЗ 16-ын 6, 7, 10 ба ТХЗ 17-ийн 14,16,17-р ЗОРИЛТУУД
9. “Бизнес ба хүний эрх”сургалт ба ИРГЭД-МАНЛАЙЛСАН сургалт ба судалгаа. Өвөрхангай аймгийн Арвайхээр, 2024.11.14-15
10. “Уур амьсгалын өөрчлөлтөөс учирсан хор хохирлын тухай” ИРГЭД МАНЛАЙЛСАН сургалт ба судалгаа. Сүхбаатар аймгийн Дарьганга суманд зохион байгуулав. Сургалтанд Дорнод аймгийн Баяндун сум, Хэнтий аймгийн Мөрөн сумын нийт 30 иргэд оролцож судалгаа хийх арга зүйд суралцлаа

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ:

- МУ-ын Хүний эрхийн төлөв байдлын 3-р илтгэлд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс өгсөн үөвлөмжүүдийн хэрэгжилтэд хийсэн дунд хугацааны үнэлгээний тайлангийн хэлэлцүүлэг
- “АСУУДЛАА ЯРИЛЦАН ХАМТАРЧ АЖИЛЛАЦГААЯ!” Олон талын хэлэлцүүлэг: Уул уурхай, байгаль орчин, хүний эрх 2024.05.21
- СУМАНДАА ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ЦОГЦЛООЁ, Хөгжилд иргэний орон зай , ардчиллыг бэхжүүлэе! Олон талын хэлэлцүүлэг: Асуудал ба шийдэл
- “Хөгжилд Иргэний орон зай, ардчиллыг бэхжүүлэе” олон талын хэлэлцүүлэг. Дорноговь аймгийн Хатанбулаг, Улаанбадрах, Даланжаргалан сум. 2024 оны 5-р сарын 24-29
- “Ардчиллыг бэхжүүлэх иргэний нийгмийн зураглал” Үндэсний хэлэлцүүлэг, УБ хот, 2024.08. 14

18 ДАХЬ ТУРШЛАГА СОЛИЛЦОХ УУЛЗАЛТ /Дорноговь, Дорнод, Хэнтий, Сүхбаатар, УБ хотын МХБүлэг, холбоодын гишүүд/ Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Их нартын ТХГ, 2024.07.16-21-ны хооронд явагдав.

НӨЛӨӨЛЛИЙН АЖЛУУД:

- НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны 56-х хуралд 3 хүн малчин оролцож өөрсдийн дуу хоолойгоо хүргэлээ. Швейцарь улсын Женев хотын 2024.06. 17-30
- Нийтийн сонсгол /Хэнтий аймгийн Мөрөн сум, Дорнод аймгийн Баяндун сум, Сүхбаатар амйгийн Дарьганга суманд амжилттай зохион байгуулаа.
- Хүний Эрхийн хамгаалагчдын 6-р зөвлөгөөн: ХЭХ-ийн Эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах нь: АСУУДАЛ БА ШИЙДЭЛ 2024.10.1-2
- Улс төрийн нам, эвслийн сонгуулийн хөтөлбөрт тогтвортой хөгжлийн зорилтууд тусгагдсан байдал, Сэтгүүлчдэд зориулсан уулзалт 2024.06.19
- ЮПР-ын зөвлөмжийн дунд хугацааны үнэлгээний тайлангийн дүнг 12 сарын 10нд ХЭФ-ын гишүүдтэй хамт УИХ-ын Хүний эрхийн дэд хороонд (ХЭДХ) хүргэж өгсөн. Үүний дүнд ХЭДХ 2024 оны 12 сарын 23-нд ХЭФ-ын төлөөллийг хүлээн авч уулзсан.



ВИДЕО / ПОСТЕРУУД

- “Уур амьсгалын өөрчлөлтөөс учирсан хор хохирлын тухай” малчин, тариаланчдад хэрхэн нөлөөлсөн, баримт нотолгоо нь дээр суурилсан судалгааны үр дүнгийн талаар баримтжуулсан 18 мин видео баримт кино гарсан.
- ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ ба ХҮНИЙ ЭРХ сэдвээр 9 постер бэлтгэсэн
- “Уур амьсгалын өөрчлөлтөөс учирсан хор хохирлын тухай” малчин, тариаланчдад хэрхэн нөлөөлсөн, баримт нотолгоо нь дээр суурилсан судалгааны үр дүнгийн талаар 14 помтер гарч сошиалоор гарсан

САНХҮҮГИЙН ЕРӨНХИЙ БАЙДАЛ 2024 ОН

2024 оны орлого 1-ээс 12 сар

Доноруудаас	USD	MNT	Эзлэх %
Тогтвортой хөгжлийн төлөөх ажиллагаа, Дэлхийн ИНБ	1,750.00	5,964,910.00	1.38
Ази Номхон далан эмэгтэйчүүд хууль ба хөгжилд. ИНБ	4,839.00	16,463,970.05	3.82
ФОРУМ-АЗИ Төсөл Азийн ИНБ	81,485.00	276,064,770.70	64.08
"Ахмадад тусла" Дэлхийн ИНБ	3,140.15	10,619,987.30	2.47
"Төлсөн авснаа нийтэл" Дэлхийн ИНБ	9,950.00	33,635,278.50	7.81
Азийн ардчиллын сүлжээ ИНБ	10,000.00	33,913,500.00	7.87
Эдийн засаг нийгэм соёлын эрхийн сүлжээ. Дэлхийн ИНБ	7,347.01	25,012,575.13	5.81
Нээлттэй нийгэм форум сан ТББ	668.51	2,286,485.00	0.53
Монголын эмэгтэйчүүдийн сан	5,645.99	19,310,700.00	4.48
Нийт		401,674,991.68	93.24
Байгууллагын орлого			
Түрээсийн орлого	1,981.14	6,776,000.00	1.57
Хүүний орлого	214.83	734,484.40	0.17
Бусад орлого			
Нийт		7,510,784.40	6.76
НИЙТ ДҮН		430,782,961.08	100.0

Байгууллагын зардал

Хөтөлбөр	USD	MNT	Эзлэх %
Хүний эрхийн нөлөөлөл, хамгааллын хөтөлбөр		164,610,478.43	50.69
Хамт олныг хөгжүүлэх хөтөлбөр		78,465,424.10	24.16
Захиргааны зардал		81,680,226.48	25.15
Нийт дүн		324,756,129.01	100.0

2024 оны тайлан тэнцэл
MNT

2024 оны 1 сарын 1-ний эхий үлдэгдэл
1,257,584

Орлого
430,782,961

Зарлага
324,756,129

2024 оны 12 сарын 31-ний эцсийн үлдэгдэл



SD

370

125,950

94,950

31,367

107,284,416

Дарга:

Г.Уранцоож

Ня-бо:

Б.Өнөрбат